



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/749

Булган сум

Орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дугаар хэсгийн 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Булган сумын Тохижилт үйлчилгээний анги, “Булган жолоо” ХХК, “Залман хангай” хоршоонд тус тус олгосугай.

2.Орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, чанартай хүргэхийг Булган сумын Тохижилт үйлчилгээний анги (Ц.Даваадорж), “Булган жолоо” ХХК-ийн захирал (П.Галнэмэх), “Залман хангай хоршоо” дарга (Б.Уянга)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг шийдвэрлүүлэн ажиллахыг Автотээврийн төв Булган салбарын дарга (Н.Баасанжаргалд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР